



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2, Зэвсэгт хүчний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Төрийн өмчийн хорооны 2001 оны 615 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгөнд оруулах хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, хяналт тавих, хүлээн авах, тооцож баталгаажуулах ажлыг зохион байгуулах журам”-ыг тус тус зөрчиж Батлан хамгаалах яамны харьяа Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Улаанбаатар хотын Багахангай дүүргийн Өндөр довд байршилтай, төрийн тусгай хэрэгцээний газарт байрлаж буй барилга байгууламжид хөрөнгө оруулалт хийхийг зөвшөөрсөн Төрийн өмчийн хорооны 2013 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 347/а дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

2. Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бригадын генерал Х.Батбилэгт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан хөрөнгийг түрээсэлж буй этгээдээс хүлээн авах ажлыг зохион байгуулж, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авах;

2.2. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ

0000199



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 11 дугаар сарын 12-ний өдрийн
58.. дугаар тогтоолын хавсралт

“ХАНГАЙ ХАН ӨНДӨР” ХХК-ИАС ХҮЛЭЭН АВЧ
БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ МЭДЭЛД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Объектын талбайн хэмжээ, м.кв	Нийт балансын үнэ (төгрөг)
1	Цэргийн байр	ш	1	245	12,976,000.00
2	Дизелийн байр	ш	1	58	4,000,000.00
3	Шатахууны станц	ш	1	24	1,350,000.00
4	Худаг	ш	1	14	825,000.00
5	Шалган нэвтрүүлэх байр	ш	1	22.8	350,000.00
6	Шилэн хүлэмж	ш	1	28	56,800.00
7	Уурын ванн	ш	1	24	120,000.00
8	Агуулах /модон/	ш	1	32	560,000.00
9	Цахилгааны дэд станц	ш	1		1,465,000.00
10	Холбооны зангилаа КС-18-3	ш	1	432	12,500,000.00
11	Уурын зуух	ш	1	393	9,165,000.00
12	Таримал мод	ш	30		36,000.00
	Нийт дүн				43,403,800.00
					(дөчин гурван сая дөрвөн зуун гурван мянга найман зуун)